

ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

/2023.05 сар/

Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар

2023.05.15

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2023 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО							
1	3.3.9. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.	2. Ноос, ноолуурын салбарын эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлнэ.	2021- 2024	-	Төсөл хэрэгжүүлэхэд санхүү, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх	Хоршоо хөгжүүлэх сангаас олгох зээлийн тэргүүлэх чиглэл сумын ИТХуралаас батлагдаагүй бөгөөд ноос, ноолуурын салбарын эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн төсөл ирээгүй.	-
2	3.7.4. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууриныг тодорхойлж, агаарын тээвэр, авто зам, төмөр замын сүлжээнд холбоно.	5. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулна.	2020 - 2024	-	Журам, заавар арга зүйн баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулна.	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”, “Сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-тэй уялдуулан сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулдаг. 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100

3	3.7.9. Хуримтлалын нэгдсэн санг байгуулан төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан 150 мянган өрх, айлыг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, орон сууцны хорооллыг барих ажлыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан үе шаттай эхлүүлнэ.	8. Аймгуудын төвд түрээсийн орон сууц барих ажлыг хамтран зохион байгуулна.	2020 - 2024	300 000 000	10 аймагт түрээсийн орон сууцны төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.	Орон нутагт ажиллахаар ирж буй төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлэхийн зорилгоор 40 айлын орон сууцны барилгыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 2022 онд эхлүүлээд гүйцэтгэл 70 хувьтай явж байна. Сумын хэмжээнд төрийн албан хаагчдад зориулсан 10 айлын нийтийн байрыг засварлахаар тендэр шалгаруулалтын ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	70
Зорилтын дундаж үнэлгээ							85
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО							
4	4.3.11. Гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг байгууллага, иргэдэд шуурхай хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Онцгой байдлын байгууллагын техник, тоног төхөөрөмжийн стандартын түвшин, хангалтыг дээшлүүлэх, гамшгийн үеийн харилцаа холбоог сайжруулна. Цаг агаарын аюул, гамшгийн үед үзэгдэлд суурилсан амжиж анхааруулах орон нутгийн мэдээг үүсгэж, аймаг, сумын төвөөс малчдад хүргэн түгээж, бэлэн байдалд орох боломж бүрдүүлэх зорилгоор орон нутгийн мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий цогцолборуудыг эрсдэл	2. Цаг агаарын гэнэтийн аюулт үзэгдлээс амжиж анхааруулах орон нутгийн дэд тогтолцоог дэмжин хөгжүүлэх говь, хээрийн бүсэд аюулаас сэрэмжлүүлэн анхааруулах 17 цогцолбор байгуулна.	2021 - 2024	3,022,4 50	Гамшгаас хамгаалах зардал 23,5 сая төгрөг төсөвлөх	2023 оны жилийн төсөвт гамшгийн эрсдлийг бууруулах, гамшгаас хамгаалах зардалд 23.500 сая төгрөг төсөвлөж сумын ИТХ-ын тогтоолоор батлуулсан. Гамшгаас хамгаалах арга хэмжээний зардалд малчдад хүргэх масс мессэж үйлчилгээний зардалд 1,3 сая төгрөг тусгаж батлуулсан. Өдөр бүр цаг агаарын мэдээг цахим хуудсанд байршуулахаас гадна цаг агаарын аюулгүй үзэгдлээс сэрэмжлүүлэх мэдээг тухай бүрт нь цахимд болон мессенжер чатаар мөн Онцгой байдлын газраас нэгдсэн мсж үйлчилгээгээр 5 удаагийн давтамжтай, 6 багийн нийт 725 малчин өрхийн иргэдэд, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлж, байгалийн гамшгийн эрсдэлийг 80 хүртэл хувиар бууруулсан. Мэргэжлийн албадыг сургаж дадлагажуулах, бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор Гамшгаас хамгаалах команд штабын сургалтыг 04 сарын 05-ны өдөр зохион байгуулан 1,722,450 төг зарцуулсан.	90

	өндөртэй байгуулна.	бүсүүдэд						
5	4.6.3. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ.		1. Аймаг, нийслэлийн орон нутгийн хамгаалалтын төлөвлөлтийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавина.	2020 - 2024	-	Аймаг, нийслэлийн орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг батлуулах Батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх төсвийг батлуулах. Хэрэгжилтийг ханган ажиллах	Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хавсралт мэргэжлийн сумангийн удирдлагын томилгоог тодотгож аймгийн цэргийн штабт хүргүүлсэн. Сумын Засаг даргын А/01 тоот захирамжаар 2023 оны цэргийн бүртгэлийг зохион байгуулж нийт 3080 иргэн хамрагдахаас биеэр 2130, e-mongolia цахим системээр 459, нийт 2589 иргэн бүртгүүлж 84,1 хувийн биелэлттэй, хамрагдаагүй 491 иргэн байна. 2023 оны цэргийн тоо бүртгэлийн мэдээг өмнөх онтой харьцуулахад биеэр бүртгүүлсэн иргэд 16%, цахимаар бүртгүүлсэн иргэд 1,2 хувиар өсөж, бүртгэлд хамрагдаагүй иргэд 58,5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Сумын хэмжээнд тайван цагт хугацаат цэргийн албанд эрүүл мэндээр тэнцэхгүй 25 иргэнийг Цэргийн эмнэлэгийн комиссын үзлэгт хамруулж 12 иргэдийг газар дээр нь цэргийн албанд татахаас чөлөөлөх ажлыг зохион байгуулсан. Мөн Батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сурталчлах, Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх арга хэмжээний хүрээнд багийн Засаг дарга нар эцэг, эхчүүдийн хамт Зэвсэгт хүчний 016, 015, 0311 дугаар нэгтгэлд хугацаат цэргийн алба хааж буй цэрэг дайчидтай уулзалт хийсэн.	100
Зорилтын дундаж үнэлгээ							95	
ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО								

6	5.1.4. Гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд "Эко жорлон" арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.	1. Гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлнэ.	2020 - 2024	-	Улаанбаатар хот болон төв суурин газрын 1000-аас доошгүй жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлсэн байна.	06-р сард 3-р багийн нутаг Баянбулагийн эгнээний "Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГ-ын гүний худгийн ойролцоох 100 метрт байгаа айлуудын нүхэн жорлонг өөрсдийнх нь оролцоотой эко нойл болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	30
7	5.1.8. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ.	1. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээнэ.	2020 - 2024	-	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 2000 га талбайд нөхөн сэргээлт хийсэн байна.	Сумын 1-р багийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэлийн зориулалтаар үйл ажиллагаа явуулдаг 14 компани "Байгаль орчны менежмент"-ийн төлөвлөгөөг батлуулсан бөгөөд төлөвлөгөөний хүрээнд ногоон байгууламж бий болгох, хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах тал дээр хамтран ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар 4 компани эзэмшил газраа 3 нэр төрлийн 1200 мод тариалаад байна.	90
Зорилтын дундаж үнэлгээ							60
ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
8	6.2.8. Инженерийн хангамжтай орон сууц болон хувийн сууцны хангамжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.	1. Инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг сайжруулах замаар аймаг бүрт гэр хорооллын 600-аас доошгүй өрхийг инженерийн хангамжид холбож, орон сууцны нөхцөлийг сайжруулна.	2020 – 2024	-	Гэр хорооллын 2600 өрх инженерийн сүлжээнд холбогдсон байна.	Сумын 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 530 м цэвэр усны шугам татаж цэвэр усны худаг хийгдэхээр төлөвлөгдөн төндөр шалгаруулалт зохион байгуулагдаж байна. Тус ажлын хүрээнд гэр хорооллын айл өрх инженерийн сүлжээнд холбогдох бүрэн боломжтой юм.	50
9	6.2.14. Хөдөө орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн худалдаа,	2. Хөдөө орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн худалдаа,	2021 - 2024	4.9 тэрбум	Холбогдох судалгаа хийнэ.	Сумын хэмжээнд идэвхитэй үйл ажиллагаагаа явуулж буй 16 хоршооны дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж ХААХХолбоод хүргүүлсэн.	70

	<p>борлуулалтыг дэмжих дэд бүтцийг бий болгон бизнес эрхлэх нэн таатай орчныг бий болгоно.</p>	<p>борлуулалтыг дэмжих дэд бүтцийг бий болгон бизнес эрхлэх нэн таатай орчныг бий болгоно.</p>				<p>ХААХХолбоотой хамтран хоршооны гишүүдийг чадавхижуулах, үйл ажиллагааг нь өргөжүүлэх, бусад аймаг сумын хоршоодын үйл ажиллагаатай танилцах туршлага солилцох, уулзалт зөвлөгөөн зохион байгуулах талаар 15 заалт бүхий ажлын төлөвлөгөөг боловсруулсан.</p> <p>Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Жижиг дунд үйлдвэрийн газар, Best сургалтын төвтэй хамтран 2023 онд Жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарын хөнгөлттэй зээл, санхүүгийн дэмжлэгт хэрхэн хамрагдах тухай сургалтыг зохион байгуулж орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 29 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл хамрагдсан. Мөн аймгийн ЖДҮДСангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар 7 аж ахуйн нэгж 857,5 сая төгрөгний төсөл хүргүүлээд байна.</p>	
Зорилтын дундаж үнэлгээ							
						60	

ЗГҮАХ-ИЙН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО

№	Зорилт	Арга хэмжээний тоо	Үүнээс					Биелэлтийн хувь	
			100 хувь	90 хувь	70 хувь	50 хувь	30 хувь	Арга хэмжээний үнэлгээ	Зорилтын үнэлгээ
1.	3	3	1		1				85
2.	4	2	1	1					95
3.	5	2		1			1		60
4.	6	2			1	1			60
Дундаж үнэлгээ		9	2	2	2	1	1		75

СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР